



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/259

Улаанбаатар хот

Зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөр эрхлэлтийн нийслэлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг доор дурдсанаар шинэчлэн баталсугай:

- Ахлагч -Нийслэлийн ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч
- Гишүүд:
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга;
 - Улаанбаатар хотын ажил олгогч эздийн холбооны тэргүүн, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирлын орлогч /тохиролцсоноор/;
 - Монголын үйлдвэрлэлийн хоршооллын төв холбооны тэргүүн /тохиролцсоноор/;
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес инкубатор төвийн захирал /тохиролцсоноор/;
 - Улаанбаатар хотын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дарга /тохиролцсоноор/;
 - Улаанбаатар хотын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дэд дарга /тохиролцсоноор/;
 - Улаанбаатар хотын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны зохион байгуулагч /тохиролцсоноор/.

Нарийн
бичгийн дарга

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн хөдөлмөрийн асуудал хариуцсан
мэргэжилтэн.

2.Хөдөлмөр эрхлэлтийн талаарх хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийгмийн түншлэгч талуудын оролцоог ханган, үйл ажиллагаагаа Нийслэлийн Засаг даргад тухай бүр тайлагнаж байхыг Хөдөлмөр эрхлэлтийн нийслэлийн зөвлөлд даалгасгай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан “Хөдөлмөр эрхлэлтийн нийслэлийн салбар зөвлөл байгуулах тухай” Нийслэлийн Засаг даргын 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/186 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



С.БАТБОЛД